



АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2.1. Төслийн нэр, төрөл	3
2.2. Төслийн зорилго	3
2.3. Төсөл хэрэгжүүлэгч	3
2.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	3
2.5. Төслийн байршил.....	3
2.6. Төсөл хэрэгжсэн орчны тойм зураг.....	3
2.7. Төслийн хүчин чадал	3
2.8. Төслийн үндсэн тоног төхөөрөмж	4
2.9. Төсөл хэрэгжих орчны товч танилцуулга	4
2.9.1. Цахилгаан хангамж	4
2.9.2. Усан хангамж.....	4
2.9.3. Харилцаа холбоо	4
2.9.4. Зам тээвэр.....	5
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	6
2.1. Агаар орчин хамгаалахад авсан арга хэмжээ	6
2.2. Хөрсөн бүрхэвч хамгаалахад авсан арга хэмжээ	7
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
НАЙМ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	28
АРВАН. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	29
АРВАН ХОЁР. ДҮГНЭЛТ.....	30



ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт № 1. Талбайн солбицол	3
Хүснэгт № 2. Уулын ажлын үндсэн тоног төхөөрөмж	4
Хүснэгт № 3. Агаар орчны нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ.....	6
Хүснэгт № 4. Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэлээс сэргийлж нөлөөллийг бууруулах, арилгах, хянах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	7
Хүснэгт № 5. Усны бохирдлоос сэргийлж, нөлөөллийг бууруулах, арилгах, хянах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ	7
Хүснэгт № 6. Биологийн төрөл зүйлийг хамгаалах нөлөөллийг бууруулах арилгах, хянах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ	8
Хүснэгт № 7. Нөөц баялгийг зохистой ашиглах арга хэмжээ.....	8
Хүснэгт № 8. Ажиллагсдын эрүүл мэндийн талаар авсан арга хэмжээ	8
Хүснэгт № 9. Удирдлага зохион байгуулалтын ажлын талаар авсан арга хэмжээ	9
Хүснэгт № 10. Нөхөн сэргээлт хийсэн талбайн мэдээлэл	10
Хүснэгт № 11. Нөхөн сэргээлтийн гүйцэтгэл	10
Хүснэгт № 12. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт	21
Хүснэгт № 13. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	27
Хүснэгт № 14. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын талаар авсан арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	28
Хүснэгт № 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнасан хуваарь	29
Хүснэгт № 16. Байгаль орчныг хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусгах ОХШХөтөлбөрийн ажлын хэмжээ, холбогдох зардлын товчоо	29
Хүснэгт № 17. “Эл Ти Ди” ХХК-ний “Шийрийн хөндий-1”-ын уурхайн 2022 оны байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлын товчоо	29

ХАВСРАЛТУУД

1. ААН-ийн гэрчилгээний хуулбар
2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
3. ЭБМЗ-ийн дүгнэлт, тушаалын хуулбар
4. ТЭЗҮ-ийн дүгнэлт, тушаалын хуулбар
5. Шинжилгээний хариу, төлбөрийн баримт
6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн дүгнэлт
7. Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан тухай акт
8. Хог хаягдлын гэрээ, хогны төлбөрийн баримт
9. Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрийн баримт
10. Нөөцийн хөдөлгөөний Маягт №3а
11. АМНАТ-ын төлбөр төлсөн баримт
12. Аудитын тайлан, дүгнэлт /Ногоон гэрэлт ирээдүй/
13. Нөхөн сэргээлтийн зураг



НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төслийн нэр, төрөл

“Шийрийн хөндий-1” алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт.

2.2. Төслийн зорилго

2022 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр батлагдсан алтыг олборлоход учрах сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээлтийн ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж унаган төрхөнд нь ойртуулах.

2.3. Төсөл хэрэгжүүлэгч

“Эл Ти Ди” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: **9011150133**

Регистрийн дугаар: **5226759**

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: **MV-021059**

2.4. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Баянхонгор, Бөмбөгөр сум, 2-р баг-Шийрийн хөндий, “Эл Ти Ди” ХХК-ийн кэмп
Утас: 98844463, Захирал Д.Номон Утас: 88114463

2.5. Төслийн байршил

“Шийрийн хөндий-1” алтны шороон орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Баян-овоо сумдад хамаарагдах бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт 760 км-т, Баянхонгор аймгийн төвөөс 80 км, Бөмбөгөр сумын төвөөс зүүн урагш 25 км зайд оршдог.

Хүснэгт № 1. Талбайн солбицол

№	Уртгаг			Өргөрөг		
1	99	55	47.89	46	7	28.72
2	99	54	42.62	46	7	28.72
3	99	54	42.62	46	9	41.58
4	99	55	47.89	46	9	41.58

2.6. Төсөл хэрэгжсэн орчны тойм зураг

2.7.





Төслийн хүчин чадал

Ашиглалтын ажлыг 2022 онд “Шийрийн хөндий-1”-ийн 6-В блокд явуулсан ба дотоод овоолгоор нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын явцад хамт гүйцэтгэж уг ордыг хаягдал багатайгаар орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэн ашигласан. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагааг явуулах учир олборлолт явуулах үедээ төлөвлөсөн блок дээрээ ажилласан. Улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарсан. Харин техник тоног төхөөрөмжүүдэд үзлэг, үйлчилгээ, урсгал засвар хийх хугацааг сард 2-4 өдөр тогтмол хийж байсан.

2.8. Төслийн үндсэн тоног төхөөрөмж

“Шийрийн хөндий-1” алтны шороон ордод уулын ажил явуулахад дор дурьдсан техник хэрэгслийг ашиглахаар тооцсон байна.

Хүснэгт № 2. Уулын ажлын үндсэн тоног төхөөрөмж

Д.д	Тоног төхөөрөмж	Нийт
1	Hyundai Robex 380LC Эксковатор (хөрс хуулалт, элс олборлолт)	1
2	Hyundai 300LC Эксковатор (хөрс хуулалт, элс олборлолт)	1
3	Shantui SL50W Ковш (Элс, эфель, галь)	1
4	XCMG ZL50GN Ковш (Элс, эфель, галь)	1
5	Nord benz Автосамосвал	3
6	ПГШ-60 Угаах төхөөрөмж	1
7	Bongo-3 Ачааны машин	1

2.9. Төсөл хэрэгжих орчны товч танилцуулга

2.9.1. Цахилгаан хангамж

Олборлолт явуулсан нутаг дэвсгэр нь төвийн эрчим хүчтэй холбогдсон тул бага оврын баяжуулах үйлдвэр, уурхайн ашиглалтын талбай, ажиллагсдын байр болон тосгоны цахилгааны хэрэглээг хангаж ажилласан болно.

2.9.2. Усан хангамж

Унд ахуйн усны хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг. Харин алттай элс угаахад шаардагдах технологийн усыг эргэлтийн усан сангаас хангаж усан санг сэлбэх хэрэгцээг гүний худгийн уснаас ашиглах замаар шийдвэрлэж байна.

Ордын талбай нь ус зүйн хувьд Төв Азийн гадагшаа урсацгүй голуудын ай савд багтах ба тус дүүргийн хэмжээнд Хангайн нурууны гол усан хагалбарын урд хажуугаас эх авсан Түйн, Нарийн зэрэг тогтмол устай голууд байдгаас гадна олон тооны жижиг нуур, булаг шанд, инженерийн хийцтэй гар худгууд тэмдэглэгдэнэ.

Эдгээр гол горхи, булаг, уст цэгүүд нь цэнгэг устай, хүн малын ундаа, газар тариаланд өргөн хэрэглэгдсээр иржээ.

Ордын талбай орчимд гар болон инженерийн гар хийцийн худаг элбэгтэй бөгөөд нутгийн оршин суугчид, мал амьтад энэхүү худагнуудаас ундаалдаг.

2.9.3. Харилцаа холбоо

Хот хоорондын харилцаанд үүрэн холбооны станц ашиглана. Үйлдвэрлэлийн дотоод үйл ажиллагааны зориулалтаар гар удирлагат радио холбооны станци ашиглана.



2.9.4. Зам тээвэр

Улаанбаатар хотоос баруун зүгт 760 км-т байрлах ба Улаанбаатар-Баянхонгорын улсын чанартай засмал замаар хүрдэг. “Шийрийн хөндий-1” алтны шороон орд нь Бөмбөгөр сум хүртэл 25 км, Баянхонгор аймгийн төв хүртэл 80 км засмал замаар холбогдох бөгөөд өөр хоорондоо машин хөсгөөр саадгүй зорчих боломжтой.



ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулж буй гол нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах.

Мөн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага, зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгасан байх шаардлагатай.

Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааныхаа зардалд багтаан төлөвлөж зарцуулах.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын биелэлтийг тайлагнаж бичих энэхүү ажлын гол зорилт болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2.1. Агаар орчин хамгаалахад авсан арга хэмжээ

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны үед болон овоолго, авто тээврийн зам зэргээс салхины үйлчлэлээр тоос, шороо хийсч агаар орчныг бохирдуулдаг. Хавар, намрын хуурайшилттай үед тоосжилт бууруулах арга хэмжээ авах зорилгоор шүүрлийн усаар усалж тоосжилтыг бууруулсан ба тоосжилт ихтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилчдыг тусгай хамгаалах хэрэгсэлээр хангасан байна.

Хүснэгт № 3. Агаар орчны нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
1	Уурхайн тээврийн үндсэн замуудыг хайрган хучилттай болгож тоос босохоос сэргийлэх арга хэмжээ авах	2022 он	800.0	700.0	Уурхайн дарга
2	Хуурайшилттай үед хайрган хучилтгүй уурхайн ухааш доторхи зам, талбайг усалж тоосыг дарж байх	2022 он	180.0	360.0	Ажилтан
3	Машин механизмуудын бүхээгийг тоос орохгүйгээр тусгаарлаж бүхээгт цэвэр агаар оруулах арга хэмжээ авах	2022 он	ҮАЗ*	ҮАЗ	
4	Нөхөн сэргээлтэнд ажиллах хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулж, хөлдгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгахад	2022 он	250.0	ҮАЗ	
5	Уурхай орчмын агаарын бохирдлын дээж авч шинжилүүлж, дүгнэлт гаргуулж холбогдох арга хэмжээ авч байх	2022 он	ОХШ-ний хөтөлбөрт тусгасан	ОХШ-ний хөтөлбөрт тусгасан	
Нийт			1230.0	1060.0	

ҮАЗ* – үйл ажиллагааны зардал

**2.2. Хөрсөн бүрхэвч хамгаалахад авсан арга хэмжээ**

Уурхайн олборлолтод өртсөн газрын хөрс, геологийн тогтоц эвдрэх, машин механизмын хөдөлгөөний улмаас элэгдэлд орох, тоос болон машин механизмын утаатай хамт хаягдах хорт хий, хүнд металл зэргээр орчны хөрс, ургамал бохирдох зүйлүүдийг анхаарч ажилласан.

Хүснэгт № 4. Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэлээс сэргийлж нөлөөллийг бууруулах, арилгах, хянах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
1	Уурхайн замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлэн ухуулах самбар хийж байрлуулах, ухуулга суртчилгааг хийх	2022 он	150.0	350.0	Уурхайн дарга
2	Ашиглалт явуулах талбайн үржил шимт хөрсийг тусад нь хуулж 2 м-ээс өндөргүй овоолон хадгалж, түр овоолго хийх	2022 он	400.0	650.0	
Техникийн нөхөн сэргээлт					
3	Дотоод овоолгын тэгшилгээг /7.06 га/	2022 он	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан		Уурхайн дарга
4	Үржил шимт хөрсөөр хучих /0.63 га/	2022 он			
5	Уурхайн хажуугийн тэгшилгээ хийхэд	2022 он			
Биологийн нөхөн сэргээлт					
6	Олон настын үр цацах /0.63 га/	2022 он	НСТ-д тусгасан		Уурхайн дарга
7	Хөрсний шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулж ажиллах	2022 он	ОХШ-ний хөтөлбөрт тусгасан		
Нийт			550.0	1000.0	

2.3. Усан орчин хамгаалахад авсан арга хэмжээ

Олборлолтын явцад шатах тослох материалын асгаралт, ахуйн бохир усны нэвчилт зэргийн нөлөөгөөр орд орчмын хөрсний болон гүний ус бохирдох зэргээр усны чанар, нөөцөд сөрөг нөлөө учруулж болзошгүй зүйлүүдийг анхаарч ажилласан. Мөн тус уурхайн ажиллагсдын унд ахуйн хэрэгцээний усыг уурхайгаас хойд зүгт 28 км зайд орших Бөмбөгөр сумын төвийн гүний худгаас хангасан ба ашигласан усны төлбөр тооцоог тоолуурын заалтаар цаг хугацаанд төлсөн болно.

Хүснэгт № 5. Усны бохирдлоос сэргийлж, нөлөөллийг бууруулах, арилгах, хянах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
1	Ус ашиглалтын гэрээг Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаатай хийх	2022 он	100.0	200.0	Геологич
2	Ус ашиглалтын төлбөрийг төсвийн дансанд оруулах	2022 он	ҮАЗ		Нягтлан бодогч
3	Ус ашиглалтын тайлан бүртгэлийг Бөөнцагаан, Орог нуурын сав газрын захиргаанд тайлагнаж байх	2022 он			
4	Уурхайн үндсэн талбайг үерийн уснаас сайтар хамгаалж суваг шуудуу татах, далан хаалт байгуулах	2022 он			
5	Бохир усан сангийн даланг өндөрлөх зэргээр бохир ус халихаас сэргийлж байх	2022 он	800.0	350.0	Уурхайн дарга
6	Усны шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах	2022 он	ОХШ-ний хөтөлбөрт тусгасан		Геологич
Нийт			900.0	550.0	



Хүснэгт № 6. Биологийн төрөл зүйлийг хамгаалах нөлөөллийг бууруулах арилгах, хянах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
1	Ургамал устгах, талхлагдахаас сэргийлэх арга хэмжээ авч замын тэмдэг, тэмдэглэгээ тавих	2022 он	550.0	300.0	Ажилтан
2	Уурхайн ухааш, нүх, суваг шуудуунд мал, амьтан унаж осолдохоос сэргийлсэн хаалт хашилт хийх	2022 он	ҮАЗ	ҮАЗ	
Нийт			550.0	300.0	

Хүснэгт № 7. Нөөц баялгийг зохистой ашиглах арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
1	Алт олборлолтын хаягдал, бохирдолтыг багасгах арга хэмжээ авч байх	2022 он	ҮАЗ	ҮАЗ	Инженер
2	Ашигт малтмал ашигласны төлбөр төлөх	2022 он	ҮАЗ	ҮАЗ	Нягтлан бодогч
3	Хяналтын сорьцлолтыг өөрсдөө болон мэргэшсэн байгууллагуудаар нарийвчлан хийлгэж үнэлгээ дүгнэлт гаргуулж байх	2022 он	250.0	110.0	
4	Техник технологийн учир шалтгаанаар гарч буй бодит хаягдлыг багасгах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх	2022 он	100.0	350.0	Уурхайн дарга
5	Хөрс хуулалтын явцад элсийг хөрстэй хамт ухаж хаягдаж үрэгдэхээс сэргийлэн хяналт явуулах	2022 он	220.0	200.0	
6	Орчинд халгүй шинэ технологийн талаар байнгын судалгаа хийж нэвтрүүлэх арга хэмжээний зардлыг уурхайн төсөвт тусгаж хэрэгжүүлэх	2022 он	100.0	ҮАЗ	
Нийт			670.0	660.0	

Хүснэгт № 8. Ажиллагсдын эрүүл мэндийн талаар авсан арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
1	Ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслээр ажиллагсдыг хангах	2022 он	200.0	ҮАЗ	Инженер
2	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамаруулах (30 хүн х 15000 төг)	2022 он	450.0		Инженер
3	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн заавар журмуудыг бүрэн боловсруулж мөрдүүлэх	2022 он	ҮАЗ	120.0	ХАБЭА-н ажилтан
4	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар курс, сургалтын болон зааварчилгаа өгөх ажил зохион байгуулах	2022 он	320.0	250.0	ХАБЭА-н ажилтан
5	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцлийг хангуулах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг төсөв төлөвлөгөөнд тусгаж ажиллах	2022 он	ТЗХ*	ҮАЗ	ХАБЭА-н ажилтан
6	Шаардлагатай объектуудад аянгын хамгаалалт, газардуулга хийх, бүрэн бүтэн байдлыг хангах, хяналт тавих	2022 он	ТЗХ*		ХАБЭА-н ажилтан
7	Уурхайн объектуудыг гал түймэрээс хамгаалах багаж хэрэгслээр хангах	2022 он	ТЗХ*		ХАБЭА-н ажилтан



8	Тосгоны хуурай хог хаягдлыг сумын хог хаягдлын цэгт хүргэж байх	2022 он	300.0	600.0	ХАБЭА-н ажилтан
9	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх	2022 он	150.0	260.0	ХАБЭА-н ажилтан
Нийт			1420.0	1230.0	

Тайлбар: ТЗХ* - төсөв зохиож хэрэгжүүлэх

Хүснэгт № 9. Удирдлага зохион байгуулалтын ажлын талаар авсан арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
1	Байгаль орчны асуудлыг нэг мэргэжилтэнд хариуцуулж дотоод хяналтын ажилтан өөрөө хяналт тавин ажиллах	2022 он	ҮАЗ	ҮАЗ	Дотоод хяналтын ажилтан
2	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэх ажлыг төлөвлөн боловсруулж БОАЖЯамаар батлуулан ажиллах	2022 он	ҮАЗ	ҮАЗ	Геологич
3	Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх	2022 он	НСТөлөвлөгөөнд тусгасан		Дотоод хяналтын ажилтан
4	Уулын ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар тодорхой ажлуудыг тусган түүнийг мөрдөн ажиллах	2022 он	300.0	150.0	Дотоод хяналтын ажилтан
5	Нийт ажиллагсдад байгалийн баялаг ашиглах, байгаль хамгаалах асуудлаар мэргэжлийн байгууллагын хүмүүс, сум, аймгийн байгаль орчны байцаагч нараар яриа хийх	2022 он	ҮАЗ	ҮАЗ	Дотоод хяналтын ажилтан
6	Сумын байгаль орчны хяналтын байцаагчтай байнгын ажил төрлийн холбоотой байх	2022 он	100.0	160.0	Геологич
7	Байгаль орчин, газар ашиглалтын тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж тайлангаа сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж байх	2022 он	250.0	ҮАЗ	Геологич
8	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг орон нутгийн иргэдийн хурал, Байгаль орчны яаманд танилцуулж байх	2022 он	200.0	ҮАЗ	Геологич
Нийт			850.0	310.0	

**ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Эл Ти Ди” ХХК нь 2022 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан талбайд угаагдсан хаягдал ефель, галийг эргүүлэн тээвэрлэж карьерийг нөхөн дүүргэлт хийн нийт 0.92 га талбайд техникийн, 10м х 30м харьцаатай 4ш талбайг хашаажуулж 0.2 га талбайд биологийн нөхөн сэргээлт буюу 2,500 ширхэг жигд модыг үрсэлгээгээр, 3,000 ширхэг гүйлс модыг үрсэлгээгээр, 4,000 ширхэг агч модыг үрсэлгээгээр, 6000 ширхэг хайлаасыг үрээр, хүлэмжинд хайлаасны суулгац 20,000 ширхэг /2 настай/ тарьсан. Техникийн нөхөн сэргээлт хийсэн болон шимт хөрсөөр хучилт хийсэн талбайг орон нутгийн нөхөн сэргээлтийг хүлээж авах комисст хүлээлгэж өгсөн болно.

Хүснэгт № 10. Нөхөн сэргээлт хийсэн талбайн мэдээлэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Талбайн хэмжээ	
1	Нийт талбай	га	574.26	
2	Эвдрэлд оруулсан талбай	га	7.53	
3	Овоолготой талбай	га	0.85	
4	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	Урд онуудад	га	5.76
		2022 онд	га	0.92
		Нийт	га	6.68
5	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	Урд онуудад	га	0.92
		2022 онд	га	0.20
		Нийт	га	1.12
6	Эрүүл талбай	га	566.73	

Хүснэгт № 11. Нөхөн сэргээлтийн гүйцэтгэл

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
Техникийн нөхөн сэргээлт					
1	- Газар шорооны ажлын үед гарсан илүүдэл ул хөрсийг эвдрэлд орсон газарт (жалга, асга г.м) асгаж тэгшлэх; - Элэгдэл, эвдрэлд өртсөн талбайг дарж булагдаа нягтруулгыг технологийн дагуу хийж, байгалийн унаган төрхөнд нь ойртуулан хэлбэржүүлэх /0.92 га/	2022 он	12,708.0	1,800.0	Уурхайн дарга
Биологийн нөхөн сэргээлт					
2	Эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийж, орон нутгийн уур амьсгалын онцлогт тохирсон ургамал, мод сөөг тарьж ургуулах /0.2 га/	2022 он	3,150.0	1,200.0	Уурхайн дарга
3	Шон суулгаж, хашаажуулах /10х30 урт, өргөнтэй 4 ш хашаа/	2022 он	-	550.0	Ажилтан
3	Хөрсний шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулж ажиллах	2022 он	ОХШ-ний хөтөлбөрт тусгасан		Геологич
	Нийт		15,858.0	3,550.0	



2022 онд олборлолт хийж буй байдал





Дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй зураг






2022 онд техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал





2022 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг





2022 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн зураг





2022 онд биологийн нөхөн сэргээлт хийж буй зураг



Зураг. Шуудуулах аргаар улиас, хайлаас мод тарих бэлтгэл хийж байгаа байдал



Зураг. Торон хашаа татаж буй байдал



Зураг. Улиас мод тарьсан байдал



Зураг. Биологийн нөхөн сэргээлт





Зураг. Биологийн нөхөн сэргээлт хийсэн байдал





ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүрээлэн буй орчинг тогтвортой хөгжүүлэх чиглэлээр, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр орон нутагтай хамтран ажиллахаар төлөвлөсөнөөс дараа ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт № 12. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Төлөвлөсөн мян.төг	Биелэлт мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
1	Хүлэмжинд ургуулсан суулгацыг тарих	Хайлаас	Уурхай орчимд	20,000	3,500.0	80.0	2022 он
		Хармаг		-	160.0		
		Улиас		1,000	1,400.0	-	
		Үрсэлгээг суулгах		1.5га	-	-	
2	Техникийн нөхөн сэргээлт хийх	Техникийн нөхөн сэргээлт хийсэн	Цахир жалга	6.98 га	3,500	6,200.0	
Нийт					8,400.0	6,440.0	



Зураг. Хүлэмжний зураг



Зураг. Хүлэмжинд хайлаас
болон хармаг модны үрсэлгээ
тарьсан байдал





Зураг. Хүлэмжинд тарьсан
наранцэцэг болон хармаг
модны үрсэлгээ






Зураг. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийхээс өмнө /Цахир жалга/





Зураг. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийхээс өмнө /Цахир жалга/



Зураг. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийсэний дараа /Цахир жалга/





**ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Шийрийн хөндий-1” уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад ямар нэгэн нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй болно.

**ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхай орчим болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай шууд болон шууд бус нөлөөллийн бүсэд түүх соёлын өв байхгүй болно. Төслийн барилга угсралтын үед ямарваа нэгэн соёлын өвийг олсон үед Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн дагуу 15 хоногийн дотор Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын байгаль хамгаалагчид мэдэгдэж нутаг дэвсгэрийн бүртгэл мэдээллийн санд анхан шатны бүртгэл хийлгэнэ. Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу урамшуулал авна.

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт № 13. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Зардал, мян.төг		Хариуцах эзэн
			Төлөвлөгөө	Биелэлт	
1	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	2022 он	ҮАЗ	ҮАЗ	Уурхайн дарга
2	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	2022 он	320.0	250.0	
3	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	2022 он	ҮАЗ	ҮАЗ	
4	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	2022 он	300.0	450.0	
Нийт			620.0	700.0	

**НАЙМ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхай нь ямар нэгэн химийн бодис хэрэглэдэггүй тул химийн эрсдэлийн менежмент төлөвлөөгүй.

ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхайн тосгоны ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэрт ажиллагсдын амрах байр, гал зуух, ажлын байр, угаалгын өрөө гэсэн үндсэн объектуудаас гарах хог хаягдлууд ордог болно.

Судалгаанаас үзэхэд уурхайд ажилладаг 1 хүнээс өдөрт 1-1.5 кг хог хаягдал үүсдэг гэдгийг тооцвол 2022 оны “Шийрийн хөндий-1” ордын хувьд өдөрт 20 хүн ажиллаж, хоногт үүсэх ахуйн гаралтай хог хаягдлын хэмжээ нь 20-30 кг болж байна. Уурхайг 185 хоног ажилласан гэж тооцвол жилд гарах ахуйн гаралтай хатуу хог хаягдлын нийт хэмжээ нь 5.5 тн байна. Үүнийг Бөмбөгөр сумын хог хаягдлын цэгт хаяж байсан. Хогын түр



цэгийг байгуулан өөрийн машинаар тээвэрлэн сумын төвлөрсөн хогын цэгт хаяхад 600.0 мян төгрөг зарцуулсан болно.

АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг уурхайн дарга хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусган ажилласан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүн, аваар ослын тайлан, уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл зэргийг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, тайлагнаж байсан.

Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгасан.

Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.

Уурхайн ажиллагсдын ихэнх нь тоосжилт, дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй ерөнхийдөө хөдөлмөрийн хүндэвтэр нөхцөлд ажиллахаас гадна нилээд хэсэг хугацааг босоогоор гүйцэтгэх ажлын нөхцөлтэй тул хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасаар хангасан юм.

Хүснэгт № 14. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын талаар авсан арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Төлөвлөсөн мян.төг	Биелэлт мян.төг	Хариуцах эзэн
1	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэх ажлыг төлөвлөн боловсруулж БОАЖЯамаар батлуулан ажилласан	2022 он	Тухай бүрт	тийм	Геологич
2	Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөлөлийг бууруулах, нөхөн сэргээх ажлыг чанартай хийлгэсэн	2022 он	Тухай бүрт	тийм	Геологич
3	Уулын ажлын төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах талаар тодорхой ажлуудыг тусган түүнийг мөрдөж ажилласан	2022 он	Тухай бүрт	тийм	Геологич
4	Нийт ажиллагсдад байгалийн баялаг ашиглах, байгаль хамгаалах асуудлаар сум, аймгийн байгаль орчны байцаагч нараар яриа хийлгэсэн	2022 он	Тухай бүрт	тийм	Геологич
5	Сумын байгаль орчны хяналтын байцаагчтай байнгын ажил төрлийн холбоотой байсан	2022 он	Тухай бүрт	тийм	Геологич
6	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг орон нутгийн иргэдийн хурал, Байгаль орчны газарт танилцуулж байсан	2022 он	500.0	450.0	Геологич
	Нийт		500.0	450.0	



АРВАН. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийг доорхи хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт № 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнасан хуваарь

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээлэлийн агуулга	Хугацааны тов /он, сар/	Зохион байгуулах газар
1	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу БОАЖЯам	Тайлан батлуулах	БОМТ	2022.12	БОАЖЯ
2	Орон нутгийн байцаагч	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2022.11	Орон нутгийн БОАЖГазар
3	Аймгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2022.11	Аймгийн БОАЖГазар
4	Аймгийн байгаль орчны газар	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2022.11	Аймгийн БОАЖГазар

Хүснэгт № 16. Байгаль орчныг хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусгах ОХШХөтөлбөрийн ажлын хэмжээ, холбогдох зардлын товчоо

№	Ажлын төрөл нэр	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Төрөл	Нийт зардал, мян.төг
1	ЦУОШГ-ын Байгаль орчны шинжилгээний лаборатори	ширхэг	4	Хөрсний дээж-1 Усны дээж-2 Агаарын дээж-1	320.0
	Дүн				320.0

Хүснэгт № 17. “Эл Ту Ди” ХХК-ний “Шийрийн хөндий-1”-ын уурхайн 2022 оны байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлын товчоо

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл	2022 оны нийт зардал, мян.төг	
		Төлөвлөгөө	Биелэлт
1	Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	7670.0	5,110
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	14254.0	3,550.0
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	4942.0	6,440.0
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	620.0	700.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1300.0	600.0
8	Удирдлага, зохион байгуулалтын зардал	500.0	450.0
9	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө		
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	480.0	320.0
	Дүн	29766.0	17,170.0



АРВАН ХОЁР. ДҮГНЭЛТ

“Эл Ти Ди” ХХК компанийн Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Баян-овоо сумдын нутагт орших “Шийрийн хөндий-1” алтны шороон орд орших MV-021059 тусгай зөвшөөрөлтэй талбайд 2019 оноос ашиглалтын ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон мониторингийн ажлыг цаг тухайд хийлгэж байсан.

Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх болон бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнд 5,110.0 мян.төг зарцуулсан байна. “Шийрийн хөндий-1” уурхайн 2022 оны байгаль хамгаалах төлөвлөгөөний нөхөн сэргээлтийн арга хэмжээнд 3,550.0 мян.төг, дүйцүүлэн хамгаалахад 6,440.0 мян.төг, осол эрсдлийн менежмент 700.0 мян.төг, ОХШХөтөлбөр мониторингийн ажилд 320.0 мян.төг, хог хаягдлын менежментийн биелэлт 600.0 мян.төг, удирдлага зохион байгуулалт, төлөвлөгөө тайлагнахад 450.0 мян.төг нийт байгаль орчин хамгаалахад **17,170.0** мян.төг зарцуулсан байна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг шинчилсэн аргачлалаар тайлагнасан боловч 2022 оны хувьд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний чиглэлээр төлөвлөгдөөгүй учир энэ талаар ажил хийгдээгүй болно.